



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2021 оны 08 сарын 19 өдөр

Дугаар А/390

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6.а, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.7, 30 дугаар зүйлийн 30.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.5, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Коронавирус (Covid-19) цар тахлын өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах хүрээнд 2021 оны 06 дугаар сарын 07-ны өдрөөс 2021 оны 08 дугаар сарын 19-ийг хүртэлх хугацаанд Арвайхээр сумын хуучин хүүхдийн төлөө төвийн байнгын шинжилгээний цэг, Нарны дөш өрхийн эмнэлгийн шинжилгээний түр цэг, Тарны хяналтын пост дээр зарцуулсан түргэвчилсэн оношлуур, хамгаалах хувцас, эм эмнэлгийн хэрэгслийн зардлыг нэгдүгээр хавсралтаар, шинжилгээний түр цэг, Тарны хяналтын пост дээр дайчлагдан ажилласан лаборант, бүртгэгч нарын илүү цагийн хөлс, нэг удаагийн тэтгэмж, Бүсийн оношлогоо эмчилгээний төвийн эмч, эмнэлгийн мэргэжилтэн нарт олгох урамшууллын зардлыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Дээрх зардалд шаардагдах 171,731,004 (нэг зуун далан нэгэн сая долоон зуун гучин нэгэн мянга дөрөв) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-т зөвшөөрсүгэй.


ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011100832

Аймгийн Засаг даргын 2021 оны ...⁰⁸
дугаар сарын ...¹⁹...-ны өдрийн ...^{4/290}... дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт



ЗАРДЛЫН ТООЦОО

| № | Бараа, ажил үйлчилгээний нэр | Тоо ширхэг | Нэгжийн үнэ | Нийт үнэ |
|-----------------|------------------------------|------------|-------------|----------------------|
| | 1 | 2 | 3 | 4 |
| 1 | Түргэвчилсэн оношлуур | 9,000 | 10,550 | 94,950,000.0 |
| 2 | Комбинзон | 1,000 | 20,000 | 20,000,000.0 |
| 3 | Түрүүтэй углааш | 1,000 | 3,000 | 3,000,000.0 |
| 4 | Нэг удаагийн бээлий | 3,600 | 500 | 1,800,000.0 |
| 5 | Нэг удаагийн бээлий | 22,000 | 500 | 11,000,000.0 |
| 6 | Арбидол | 50 | 33,800 | 1,690,000.0 |
| 7 | Норов-7 | 115 | 6,500 | 747,500.0 |
| 8 | Витамин Д3 4000мг | 805 | 520 | 418,600.0 |
| 9 | Витамин С 1000мг | 805 | 366 | 294,630.0 |
| 10 | Ибумон 400мг | 115 | 1,100 | 126,500.0 |
| 11 | Ковидын-19 багцын үнэ | 58 | 13,800 | 800,400.0 |
| 12 | Витагрип | 45 | 7,480 | 336,600.0 |
| 13 | Томзылмон | 45 | 4,200 | 189,000.0 |
| 14 | Витамин С 1000мг | 2 | 3,900 | 7,800.0 |
| 15 | Витамин Д3 4000мг | 3 | 32,150 | 96,450.0 |
| Нийт дүн | | | | 135,457,480.0 |

Аймгийн Засаг даргын 2021 оны ...08..
дугаар сарын ...19...-ны өдрийн ... дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт



ИЛҮҮ ЦАГИЙН ХӨЛС, ТЭТГЭМЖ УРАМШУУЛЛЫН ТООЦОО

| № | Зардлын нэр | Хүний тоо | мөнгөн дүн |
|---|---|------------|-------------------|
| 1 | Лаборант,бүртгэгч нарын илүү цагийн хөлс 6 сар | 18 | 4,441,620 |
| 2 | Лаборант,бүртгэгч нарын илүү цагийн хөлс 7 сар | 9 | 3,993,203 |
| 3 | Ажил олгогчийн төлөх нийгмийн даатгалын шимтгэл | 18 | 1,138,701 |
| 4 | Ковидын үед дайчлагдан ажилласан 30 хүний тэтгэмж | 30 | 13,800,000 |
| 5 | БОЭТөвийн эмч мэргэжилтэнд олгох урамшуулал | 43 | 12,900,000 |
| | дүн | 118 | 36,273,524 |